



Цаг үе, үйл явдал

ТЭМЦЭЭНД ТАСРАЛТГҮЙ ОРОЛЦСОН ОРОЛЦОГЧ ЭНЭ ХУГАЦААНД АРДЫН 150 ГАРУЙ ДУУГ СУРЧЭЭ



Үндэсний соёл урлагийг нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг дээшлүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах, Монголын үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой нийцүүлэн хөгжүүлэх, Монгол түмний ахуй амьдрал, өв соёл, ардын уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, нэгтгэл, анги, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор ЦДБЭЧ-аас санаачлан, ЗХЖШ-тай хамтран зохион байгуулж ирсэн “Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр” тэмцээн эх орондоо 18 жил, хилийн чанадад буюу БНӨСУ-д 3 дахь жилдээ амжилттай явагдаж байна.

Энэхүү тэмцээний цар хүрээ жилээс жилд өргөжиж, эхний жилд 6 анги, байгууллага оролцож байсан бол сүүлийн жилүүдэд тогтмол 30-34 анги, тэр тусмаа алслагдсан ангиуд, ҮБХИС, Цэргийн төв эмнэлэг зэрэг байгууллагууд оролцдог болсон юм.

Оролцогчдын тухайд жил бүр нэг ангиас 6 оролцогч анги, байгууллага төлөөлөн оролцож ирсэн уламжлалтай бөгөөд өнгөрсөн жилүүдэд давхардсан тоогоор 3200 гаруй алба хаагч хамрагдаж, ардын уламжлалт ёс заншлаараа өрсөлдөж байна. Жил бүр тэмцээний удирдамжийн дагуу сонгож дуулах 10 дууны жагсаалт гаргаж, ардын богино дуу, харилцаа дуу, хошин дуу, домогт дуу, баруун Монгол ардын дуу гэх мэтээр өөрчлөн зохион байгуулсаар байгаа бөгөөд уг тэмцээн зохион байгуулагдсан цагаас хойш тасралтгүй оролцсон

оролцогч энэ хугацаанд ардын 150 гаруй дууг сурч дуулсан тоон үзүүлэлт гарчээ.

Энэ хугацаанд шилдэг дэмбээчин, шилдэг дуучин, шилдэг удирдагч, шилдэг үйлчин зэргийг тодруулж, Ардын богино дуу дуулаачдын холбоо, Монгол цэргийн музей, Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо, “Говь хангай мебель”, “Талх чихэр” хувьцаат компани зэрэг үндэсний шилдэг үйлдвэрлэгч компаниудтай хамтран ажиллаж, тэмцээнийг жил бүр олон нийтийн телевизээр нэвтрүүлэн сурталчилдаг юм.

Мөн нэгтгэл, анги, байгууллагын удирдлагын бүрэлдэхүүнийг соёл урлагийн арга хэмжээнд өргөнөөр хамруулах зорилгоор ангийн захирагч нар, штабын дарга нар, ар тал, санхүүгийн дарга нарын дунд “Заавал дуулах дууны тэмцээн” зохион байгуулж ирсэн бөгөөд энэ жил Тэргүүн ахлагч нарыг оролцуулж байгаа юм.

Тэмцээнд оролцогчид мэндчилгээ, монгол шагайн харваа, маавал дуулах дууны тэмцээн, оньсон тоглоом, Баруун Монгол ардын дуу, Монголын нууц товчооноос сэдэвлэсэн асуулт, хариултаар өрсөлдөхийн зэрэгцээ өдөр бүр “Шилдэг хөгжөөн дэмжигч баг”-ийг шалгаруулж ирсэн уламжлалтай.


Зэвсэгт хүчний “Урлагийн марш тактик” хэмээн нэрлэгддэг энэхүү тэмцээн энэ жил Байлдааны гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын түүхт 90 жилийн ойн босгон дээр зохион байгуулагдаж байгаагаараа түүхэн ач холбогдолтой юм.



Түүхэнд энэ өдөр

1978 он.

ЦЭРЭГ ТАТЛАГЫН АЖЛЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ САЙДЫН ТУШААЛ ГАРЧЭЭ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-23

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.00	2,855.0
EUR	3,255.0	3,265.0
CNY	448.00	449.20
RUB	38.10	39.40
JPY	24.85	25.00
KRW	2.39	2.40

ЗУРХАЙ

2022.01.21 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 19

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХ НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Сайн нөхөртэй нөхөрлөнө
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.32-17.35
Барилдлага:
Түлэх
Шүтэн барилдлага:
Сансар
Суудал: Төмөр

Энэ өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, эрдэнийг гадагш өгөх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирах” хэмээх сайн.

ДОРНЫН ЗУРХАЙ: Морь жилтнээ аливаа үйлийг хийхэд ЭЕРЭГ сайн

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,268.377 /69.7%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,168.827 /66.7%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 979.390 30,0%
--	---	--------------------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 7677 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 200	ЭДГЭРСЭН 7361
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 331,362,580
Эдгэрсэн Нийт: 5,593,256
Нас барсан Нийт: 5,593,256



Цахим шууданд

ЦДБЭЧ-ЫН БҮЖИГЧИД МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



зохион байгуулсан энэхүү сургалтаар сонгодог бүжгийн болон улс үндэстний бүжгийн дасгал, бүжгийн түүх, бүжгийн онолын хичээлүүдийг Монгол Улсын консерваторын Бүжиг циркийн мэргэжлийн сургуулийн эрдэмтэн багш нар удирдан явуулав. Мөн тус сургалттай хамтатган Монгол Улсын консерваторын Бүжиг циркийн мэргэжлийн сургуулийн ардын бүжгийн төгсөх ангийн сурагчид ЦДБЭЧ-д практик дадлага хийж, чуулгын мэргэжлийн бүжигчдээс туршлага судлах, арга зүйн зөвлөгөө авах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан дээрх сургалтууд нь ЦДБЭЧ, Монгол Улсын консерваторын Бүжиг циркийн мэргэжлийн сургуулийн хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлсэн, үр дүнтэй ажил болсон юм.

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "ЦДБЭЧ-ын 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу чуулгын бүжгийн албаны бүрэлдэхүүн Монгол Улсын консерваторын Бүжиг циркийн мэргэжлийн

сургуультай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд 1,5 кредит буюу 48 цагийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж сертификатаа гардан авлаа. ЦДБЭЧ-ын бүжигчдийн ажлын байрандаа суралцан хөгжих, мэргэжлийн түвшнийг ахиулах зорилгоор



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2022-2023 онд үүрэг гүйцэтгэх штабын ажилтан, цэргийн мэргэжилтний сонгон шалгаруулалтыг 2022 оны 3 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулла.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд батлагдсан "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам"-тай танилцаж, НҮБ-ын штабын ажилтан, цэргийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа нэгтгэл, анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт;
3. Жолооны үнэмлэхийн хуулбар;
4. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
5. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;
6. Товч судалгаа;
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт

Анги	Албан тушаал	Цол	Овог, нэр	Нас	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа	Анги, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон огноо	ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал
------	--------------	-----	-----------	-----	-------------------------------------	-------------------------------------	--	---------------------------------

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982, 92096622/-тэй холбогдон тодруулж болно. "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам"-тай ЗХЖШ-ын цахим хуудасны эрх зүйн булан буюу <https://gsmaf.gov.mn/gsmf/cat/60> холбоосоор орж танилцана уу.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ӨНӨӨДӨР ДУУСНА



Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас хуваарь гарган хороодод ажиллалаа. Ингэхдээ тухайн хороодын цэргийн бүртгэлийн явц байдалтай танилцаж, мэдээллийн сангийн хэвийн ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар үүрэг чиглэл, заавар зөвлөмж өгч, 18 нас хүрч буй залууст цэргийн үүрэгтний

үнэмлэхийг хүндэтгэлтэй гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж, дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр бэлэг барилаа. Мөн Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн алба хаах төрлүүд, хугацаат цэргийн алба хаахын давуу талууд, эх орныхоо өмнө хүлээсэн иргэний цэргийн үүргээ нэр төртэй биелүүлэхийн ач холбогдлыг сурталчлан танилууллаа. Зарим хороодод нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Батлан хамгаалах



хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер хурандаа М.Мөнгөтулга зочноор оролцож, Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар залууст сонирхолтой илтгэл, мэдээлэл хүргэлээ.

Өнөөдөр цэргийн бүртгэл дуусах тул иргэд e-Mongolia гар утасны апплейкэшн, вэб хуудсаар, хороодын Засаг даргын Ажлын алба болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хандан амжиж бүртгүүлэхийг уриалж байна.

